Монгол Улсын Еронхийлогчийн 2017 оны сонгуульд Дипломат толоологчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бvхий иргэдийн саналыг 2017 оны 6 дугаар сарын 10-ны одрийн Бямба, 11-ний одрийн Ням гарагуудад 07:00- 22:00 цагийн хооронд Элчин сайдын яамны байранд авна.

Иргэд сонгуульд оролцож, саналаа огохийн тулд **заавал урьдчилан бvртгvvлсэн байх шаардлагатай.**

- Сонгогчдын бvртгэлийг 2017 оны 5 дугаар сарын 1-нээс 20-ны одрийг дуустал Бямба, Ням гаригуудыг оролцуулан 08:30-12:30, 13:30-16:30 цагийн хооронд хийнэ,

- Саналаа огохоор бvртгvvлэх иргэн Та иргэний шинэчилсэн бvртгэлд хамрагдсан, санал авах одор буюу 2017 оны 6 сарын 10-ны одроос омно 18 нас хvрсэн байх шаардлагатай,

- Стокгольм дахь ЭСЯ-нд ирж саналаа огох иргэд саналаа огохоор бvртгvvлэхдээ тус ЭСЯ-ны www.stockholm.mfa.gov.mn гэсэн цахим хуудаснаас СЕХ-оос баталсан "**Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд оролцох гадаад улсад байгаа иргэний бvртгvvлэх маягт"-ыг**
татаж авч боглон гарын vсгээ зурж баталгаажуулан,
**гадаад паспортын хуулбарын хамт**
ЭСЯ-нд оорийн биеэр ирж бvртгvvлэх, эсхvл боглосон бvртгэлийн маягт, паспортын хуулбараа:

- **Embassy of Mongolia**

**Svärdvägen 25B**

**182 33 Danderyd,**

**Stockholm, Sweden** гэсэн хаягаар шуудангаар, эсхvл

- stockholm@mfa.gov.mn , mongolia.embassy@yahoo.com гэсэн цахим шуудангаар, эсхvл
- https://www.facebook.com/embassyofmongolia.sweden/# гэсэн нvvр номны /facebook/-ны хаягаар илгээх замаар бvртгvvлнэ vv.

Биечлэн ирж бvртгvvлэх тохиолдолд бvртгэлийн маягтыг Дипломат толоологчийн газраас авах боломжтой богоод харин гадаад паспортоо авч ирэх хэрэгтэй. Монгол Улсын хилээр хамгийн сvvлд гарсан он, сар, одрийг гадаад паспортынхаа тэмдэглэгээнээс харах боломжтой.

Саналаа огохоор бvртгvvлж, бvртгэл нь баталгаажсан иргэд санал авах одрvvдэд ирэхдээ гадаад паспорт, иргэний vнэмлэхийн аль нэгийг **ЗААВАЛ** авч ирэх шаардлагатай болохыг анхаарна уу.
**Дээрх бичиг баримтуудын нотариатаар баталсан болон батлаагvй хуулбараар сонгууль өгөх боломжгvй болохыг анхаарна уу!**

Иргэн Та сонгох эрхээ эдэлж, Монгол Улсын торийн тэргvvнийг сонгох сонгуульд идэвхитэй оролцоно уу. Монгол Улсын Еронхийлогчийн сонгуулийн талаарх дэлгэрэнгvй мэдээллийг СЕХ-ны **www.gec.gov.mn** цахим хуудаснаас vзнэ vv.

Монгол Улсын Еронхийлогчийн ээлжит сонгуульд оролцох гадаад улсад байгаа иргэний бvртгvvлэх маягтыг эндээс авна уу.

Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа ЭСЯ, Салбар комисс № 30

Лавлах утас: 08 753 11 35